

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

**Аж ахуйн нэгж:** Ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулж буй байгууллага.

**Ажил олгогч:** Иргэнийг гэрээний үндсэн дээр ажилуулж цалин олгож буй хувь хүн, хуулийн этгээд.

**Ажилтан:** Ажил олгогч хувь хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр ажил хийж, хөдөлмөр, цалин хөлсний орлого олж буй хувь хүн.

**Амьдралын мөчлөг:** Тухайн гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн настай уялдуулж санхүүгийн хэрэгцээг нь ангилсан байдал.

**Ашиг:** Зарлагаас давсан орлогын хэсэг буюу орлого, зарлагын зөрүү.

**Аюул:** Таны хөрөнгөд хохирол учруулж болох нөхцөл байдал.

**Бараа, бүтээгдэхүүн:** Худалдах, худалдан авах, хэрэглэх, цаашид боловсруулах зориулалттай, хувь хүн байгууллагын хэрэгцээнд зориулагдсан эд зүйл.

**Бизнес төлөвлөгөө:** Бизнесийн зорилго, түүнд хүрэх арга зам, хийх ажлыг тодорхойлж тусгасан албан ёсны баримт бичиг.

**Бизнесийн байгууллага:** Хэрэглэгчдийг бараа, үйлчилгээгээр хангахад чиглэсэн ажил үйлчилгээ эрхлэх хууль ёсны зөвшөөрөл бүхий ашгийн төлөө байгууллага.

**Бизнесийн ёс зүй:** Зах зээл дээр мөрдөж буй хуулийн хүрээнд ажлаа үр дүнтэй явуулах чадвартай, хэлсэн үгэндээ хүрдэг, үнэнч, шударга байдалд тулгуурласан ажил хэргийн соёл.

**Бизнесийн зардал:** Бизнесийн үйл ажиллагааг явуулахад гарах зардлын дүн.

**Бизнесийн зорилго:** Бизнесийн үйл ажиллагаа явуулснаар хүрэхийг хүсэж буй үр дүн.

**Бизнесийн зээл:** Бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд зориулж авсан зээл.

**Бизнесийн нийгмийн хариуцлага:** Бизнес эрхлэгч явуулж буй үйл ажиллагааныхаа үр дүнгийн төлөө нийгэм, хамт олон, улс орны өмнө үүрэг хүлээж, түүнийгээ биелүүлэх чадвар.

**Бизнесийн орлого:** Бизнесийн үйл ажиллагаанаас олох орлого.

**Бизнесийн орчин:** Байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлдөг гадаад, дотоод хүчин зүйлс.

**Борлуулалтын орлого:** Бараа, үйлчилгээг хэрэглэгчдэд худалдснаар хүлээн авах мөнгөний дүн

**Бэлэн мөнгө:** Цаасан ба зоосон хэлбэрээр байгаа мөнгө.

**Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө:** Банкнаас гадуур иргэдийн ашиглаж буй болон банкуудын касс т байгаа мөнгөний дүн.

**Даатгал:** Эрсдэлийг шилжүүлэх арга буюу даатгуулагчдаас авсан хураамжийг хохирогчдод хуваарилах үйл ажиллагаа.

**Даатгалын баталгаа:** Даатгалын компанийн зүгээс даатгуулагчдаа даатгасныг баталгаажуулан өгч буй баримт бичиг.

**Даатгалын нөхөн төлбөр:** Даатгалын гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө.

**Даатгалын тохиолдол:** Даатгалын гэрээнд заасан, хохирол учруулж болох бодит үйл явц.

**Даатгалын хураамж:** Даатгуулагч амь нас, эд хөрөнгө, ашиг сонирхол, хариуцлагаа даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөр.

**Дебет карт:** Картын тооцооны харилцах данс нээж уг дансанд байгаа хөрөнгийн хэмжээнд багтааж төлбөр гүйцэтгэх зорилгоор ашигладаг санхүүгийн хэрэгсэл.

**Дэнчин:** Хуулийн этгээд ба хувь хүн зээлийн гэрээг хэрэгжүүлнэ гэдгээ баталж, зээлдүүлэгчид өгөх үнэт эдлэл, мөнгөн хөрөнгө, хөрвөх чадвар өндөртэй эд зүйлс.

**Зардал:** Аливаа үйл ажиллагааг явуулахтай холбогдуулан, тодорхой зорилгоор зарцуулж байгаа мөнгө.

**Зарлага:** Засгийн газар, байгууллага, хувь хүн тодорхой хугацаанд зарцуулсан нийт мөнгөний дүн.

**Зах зээл:** Бараа, үйлчилгээг худалдах, худалдан авах үйл явц хэрэгждэг газар.

**Зээлийн барьцаа :** Өр төлөхөө баталж, зээлийн барьцаанд тавьсан хөрөнгө, эд зүйл.

**Инфляци:** Хэрэглээний сагсанд багтсан өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшний ерөнхий өсөлтийн хувь.

**Ирээдүйн үнэ цэнэ:** Хүү болон хугацааны нөлөөллөөр өнөөдрийн мөнгө ирээдүйд хэд болохыг тооцоолсон дүн.

**Кредит карт:** Банкнаас тогтоож өгсөн тодорхой хязгаарын дотор зээлээр бараа, үйлчилгээ худалдан авах эрхтэй карт.

**Нийгмийн даатгал:** Өндөр наслах, өвчлөх, өнчрөх, осол гэмтэлд орох, ажилгүй болох зэргээр орлого олох боломжгүй болсон үед нь тэтгэвэр, тэтгэмж хэлбэрээр орлого олгодог, ашгийн төлөө бус даатгал.

**Нийгмийн халамж:** Ядуу, орлого багатай хүн амд төрөөс олгож байгаа буцалтгүй тусламж.

**Нийгмийн хариуцлага:** Хуулийн болон ёс зүйн хэм хэмжээг мөрдөн, нийгмийн ашиг сонирхлыг хүндэтгэн үйл ажиллагаа явуулж, түүний үр дүнг хүлээх чадвар.

**Нийлмэл хүү:** Дансны эхний үлдэгдэл болон хүүний орлогыг нэмсэн нийлбэр дүнгээс тооцогдох хүүний дүн.

**Нөхөн олговрын хэмжээ:** Даатгуулсан эд хөрөнгөд эрсдэл тохиолдох үед даатгалын компаниас хохирлоо төлүүлэхээр тогтоолгосон даатгалын үнэлгээний дүн.

**Орлого:** Өөрийн нөөц, боломжийг ашиглан олж буй мөнгө.

**Өнөөгийн үнэ цэнэ:** Ирээдүйд авах мөнгөний худалдан авах чадварыг өнөөдрийн түвшинд тооцоолсон дүн.

**Өр төлбөр:** Хувь хүн, байгууллагын бусдад төлөх ёстой мөнгөний дүн.

**Өртгийн хэмжүүр:** Бараа, үйлчилгээний үнийг тодорхойлох зорилгоор түүний өртгийг мөнгөөр илэрхийлэх үйл явц.

**Өртөг:** Бараа, үйлчилгээг олж авах, эсвэл үйлдвэрлэхэд зарцуулсан мөнгөн дүн.

**Санхүү:** Мөнгөтэй холбогдож үүссэн эдийн засгийн харилцааг судалдаг шинжлэх ухаан. Санхүүгийн хүрээнд хувь хүний санхүү, аж ахуйн нэгжийн санхүү, төрийн санхүү багтана.

**Санхүүгийн мэдээллийн аюулгүй байдал:** Хувь хүний мөнгө, нөөц баялагтай холбоотой мэдээллийн хамгаалагдсан байдал, нууцлал.

**Санхүүгийн төлөвлөлт:** Богино, дунд, урт хугацааны зорилгод хүрэхийн тулд ямар нөөцийг ашиглах, ямар аргыг хэрэглэхийг төлөвлөх үйл ажиллагаа.

**Санхүүгийн хэрэгсэл:** Мөнгөний үүргийг гүйцэтгэдэг, төлбөр төлөх болон хүлээн авах эрх, үүргийг бий болгож байдаг санхүүгийн бүтээгдэхүүн. Үүнд: Засгийн газрын өрийн бичиг, карт, үнэт цаас, зээл, даатгалын гэрээ гэх мэт хамаарна.

**Сахилгын дүрэм/ Ёсзүйн дүрэм:** Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх, ажиллагсдын мөрдвөл зохих алхмуудыг тодорхойлсон зааварчилгаа.

**Төлбөрийн чадвар:** Төлөх ёстой өр төлбөрөө хугацаанд нь бүрэн төлж барагдуулах санхүүгийн чадвар.

**Төлөвлөгөө:** Тодорхой зорилгод хүрэхийн тулд нөөц, боломж, эрсдэл, үйл ажиллагааг урьдчилан харсан тооцоолол.

**Төлөвлөлт:** Санхүүгээ үр дүнтэй ашиг орлоготой байхуйцаар мөнгөө удирдах үйл явц.

**Аюул:** Таны хөрөнгө болон амь насанд хохирол учруулж болох нөхцөл байдал.

**Төсвийн удирдлага:** Хувь хүн өөрийн мөнгөн хөрөнгийг (орлогыг) төлөвлөгөөтэйгээр, ухаалгаар захиран зарцуулах, бүртгэл хөтөлж хянах үйл явц.

**Төсөв:** Тодорхой хугацааны мөнгөн орлого, зарлагын төлөвлөгөө.

**Түрээсийн орлого:** Үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж гэх мэт хөрөнгийг бусдад ашиглуулсны төлөө авч буй мөнгө.

**Тэтгэвэр:** Нийгмийн даатгалын сангаас өндөр настай болон тахир дутуу болсон хүнд улсаас сар бүр олгодог мөнгө.

**Үндсэн хөрөнгө:** Үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт хөрөнгө.

**Үнэ:** Бараа, үйлчилгээг худалдан авахад төлөх мөнгөний дүн.

**Үнэт цаас:** Арилжиж бусдад шилжүүлж болдог, тодорхой үнэ цэнэ бүхий санхүүгийн хэрэгсэл.

**Хадгаламж:** Хувь хүн, хуулийн этгээдээс банкинд хүүтэйгээр хадгалуулсан мөнгө.

**Хадгаламжийн даатгалын корпораци:** Иргэдийн хадгаламжид баталгаа гаргаж буй санхүүгийн байгууллага. Монгол улсын Хадгаламжийн даатгалын корпораци нь 20.0 сая хүртэлх төгрөгийн хадгаламжид баталгаа гаргадаг.

**Хадгаламжийн сертификат:** Мөнгөө банкинд байршуулж буй хадгаламж эзэмшигчдэд банкны зүгээс олгосон үнэт цаас.

**Хөрөнгө оруулалт:** Мөнгөө өсгөж арвижуулах зорилгоор хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө худалдан авах үйл ажиллагаа.

**Хөрөнгө:** Хувь хүний өмчлөлд байгаа мөнгө, нөөц, баялаг.

**Хувийн санхүүгийн мэдээлэл:** Хувь хүний дансны үлдэгдэл, мөнгөний баримтууд зэрэг санхүүгийн үйл ажиллагааны талаарх баримт, мэдээлэл.

**Хувьцаа:** Компанид хувь нийлүүлсэн буюу хөрөнгө оруулсныг гэрчлэх үнэт цаас.

**Хуримтлал:** Ирээдүйн хэрэгцээнд зориулж хадгалсан мөнгө, хийсэн хөрөнгө оруулалт, худалдаж авсан биет хөрөнгө.

**Хүсэл:** Зайлшгүй шаардлагатай биш боловч хувь хүн түүнийг худалдан авах, хэрэглэхийг хүсэж байгаа бараа, үйлчилгээ.

**Хэм хэмжээ:** Хувь хүн, байгууллага бусдад болон байгаль орчинд сөрөг нөлөө учруулахгүйгээр үйл ажиллагаа явуулахтай холбоотой тогтоосон хууль, дүрэм, журам.

**Хэрэгцээ:** Хүний амьдралд зайлшгүй шаардлагатай, хоол, унд, хувцас, орон байр, өөрийгөө хөгжүүлэх, нийгмийн үүргээ гүйцэтгэхтэй холбоотой зардал.

**Эрсдэл:** Хүний амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгөд хохирол учирч болох магадлал.